ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 6-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/149/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он


Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/176

танай____________-ны №_____________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЗУРГААДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ОДГЭРЭЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын зургаадугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын зургаадугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.
Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Сургуулийн барилга болон бусад үндсэн хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 19.95 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй тайлан бэлтгэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөг суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион

010020030

байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 48.8 сая төгрөгийн 4 тушаалыг огт мэдээлээгүй байна.

Ebarimt-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 49 ширхэг 421.9 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 11 ширхэг 95.4 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 82.5 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **331,530,214.76** | **299,338,840.12** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **132,996,477.00** | **196,906,661.84** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **132,996,477.00** | **196,906,661.84** |
| **31210** | **Төгрөг** | **132,996,477.00** | **196,906,661.84** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 132,996,477.00 | 196,906,661.84 |
| **33** | **АВЛАГА** | **137,366,000.00** | **791,490.24** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 691,490.24 |
| **33500** | **Бусад авлага** | **137,366,000.00** | **100,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 137,366,000.00 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 100,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **61,167,737.76** | **101,640,688.04** |
| **35100** | **Түүхий эд материал** | **26,716,197.16** | **40,623,265.44** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 26,716,197.16 | 40,501,915.44 |
| 35130 | Эм боох материал | - | 121,350.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **34,451,540.60** | **61,017,422.60** |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 722,998.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,451,540.60 | 60,294,424.60 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **220,124,680.63** | **10,707,161,513.61** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **220,124,680.63** | **10,707,161,513.61** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **218,658,013.95** | **10,706,244,846.89** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | - | 6,907,558,561.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 111,396,790.40 | 292,633,690.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,926,232.35) | (58,081,030.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 112,195,475.00 | 352,325,475.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,008,019.10) | (48,103,014.90) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | - | 122,997,972.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 3,133,084,120.00 |
| 39217 | Ном | - | 3,829,074.30 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,466,666.68** | **916,666.72** |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (183,333.32) | (733,333.28) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **551,654,895.39** | **11,006,500,353.73** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **7,762,016.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **7,762,016.00** |
| **41300** | **Өглөг** | **-** | **7,762,016.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 7,762,016.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **551,654,895.39** | **10,998,738,337.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **551,654,895.39** | **10,998,738,337.73** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **551,654,895.39** | **10,998,738,337.73** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - | 551,654,895.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 551,654,895.39 | 10,447,083,442.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **551,654,895.39** | **11,006,500,353.73** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **628,140,053.16** | **11,764,793,882.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **97,400,853.16** | **10,482,732,704.14** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **97,400,853.16** | **10,482,732,704.14** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **70,000.00** | **26,935,800.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 8,137,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | 18,798,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 66,430,263.40 | 10,440,749,627.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 30,900,589.76 | 15,047,276.84 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **530,739,200.00** | **1,282,061,178.34** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **530,739,200.00** | **1,108,403,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 530,739,200.00 | 1,108,403,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **173,657,478.34** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 173,657,478.34 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **76,485,157.77** | **1,317,710,440.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **76,485,157.77** | **1,317,710,440.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **76,485,157.77** | **1,317,710,440.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **55,656,144.00** | **807,127,095.38** |
| 210101 | Үндсэн цалин | 45,965,853.00 | 582,663,060.38 |
| 210102 | Нэмэгдэл | 9,371,014.00 | 219,294,335.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 319,277.00 | - |
| 210104 | Урамшуулал | - | 5,169,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,957,029.00** | **100,358,060.54** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,730,774.84 | 68,987,269.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 556,561.54 | 8,111,694.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 445,249.63 | 6,489,353.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,312.91 | 1,513,634.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,113,130.08 | 15,256,108.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **179,323,320.34** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 23,810,820.34 |
| 210302 | Түлш, халаалт | - | 140,842,548.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 14,669,952.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,009,100.00** | **91,783,311.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 656,400.00 | 1,143,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 352,700.00 | 90,640,311.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000.00** | **314,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,000.00 | 314,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **840,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 840,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **9,240,100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 5,280,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,960,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,019,884.77** | **129,563,952.88** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,052,000.00 | 21,997,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,850,300.00 | 5,766,358.56 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,117,584.77 | 101,799,794.32 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **551,654,895.39** | **10,447,083,442.34** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **551,654,895.39** | **10,447,083,442.34** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **530,809,200.00** | **1,446,362,978.34** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **70,000.00** | **164,301,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **70,000.00** | **164,301,800.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **70,000.00** | **164,301,800.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 8,137,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | 156,164,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **530,739,200.00** | **1,282,061,178.34** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **530,739,200.00** | **1,108,403,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 530,739,200.00 | 1,108,403,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **173,657,478.34** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 173,657,478.34 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **239,000,721.00** | **1,234,365,793.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **239,000,721.00** | **1,234,365,793.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **239,000,721.00** | **1,149,381,793.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **55,656,144.00** | **807,308,117.62** |
| 210101 | Үндсэн цалин | 45,965,853.00 | 582,844,082.62 |
| 210102 | Нэмэгдэл | 9,371,014.00 | 219,294,335.00 |
| 210104 | Урамшуулал | 319,277.00 | 5,169,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,957,029.00** | **100,868,528.54** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,730,774.84 | 69,497,737.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 556,561.54 | 8,111,694.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 445,249.63 | 6,489,353.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,312.91 | 1,513,634.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,113,130.08 | 15,256,108.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **171,561,304.34** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 23,810,820.34 |
| 210302 | Түлш, халаалт | - | 133,280,532.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 14,469,952.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **162,245,998.00** | **8,456,174.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 31,217,998.00 | - |
| 210602 | Тавилга | 131,028,000.00 | 6,360,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 2,096,174.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **350,000.00** | **9,240,100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 5,280,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 350,000.00 | 3,960,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,791,550.00** | **51,947,569.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,507,850.00 | 41,301,969.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,283,700.00 | 10,645,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **84,984,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **84,984,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 84,984,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **291,808,479.00** | **211,997,184.84** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **158,812,002.00** | **148,087,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **158,812,002.00** | **148,087,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **158,812,002.00** | **148,087,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 158,812,002.00 | 148,087,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(158,812,002.00)** | **(148,087,000.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **132,996,477.00** | **63,910,184.84** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 132,996,477.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 132,996,477.00 | 196,906,661.84 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 551,654,895.39 | 551,654,895.39 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 10,447,083,442.34 | 10,447,083,442.34 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 10,998,738,337.73 | 10,998,738,337.73 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,402,034,400.00** | **1,208,795,315.16** | **193,239,084.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,402,034,400.00** | **1,208,795,315.16** | **193,239,084.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,276,796,400.00** | **1,123,811,315.16** | **152,985,084.84** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **938,131,200.00** | **807,308,117.62** | **130,823,082.38** |
| 210101 | Үндсэн цалин | 630,232,300.00 | 582,844,082.62 | 47,388,217.38 |
| 210102 | Нэмэгдэл | 286,880,800.00 | 219,294,335.00 | 67,586,465.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - | - |
| 210104 | Урамшуулал | 21,018,100.00 | 5,169,700.00 | 15,848,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **117,266,500.00** | **100,868,528.54** | **16,397,971.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,741,300.00 | 69,497,737.36 | 10,243,562.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,381,300.00 | 8,111,694.94 | 1,269,605.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,505,100.00 | 6,489,353.55 | 1,015,746.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,876,200.00 | 1,513,634.21 | 362,565.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,762,600.00 | 15,256,108.48 | 3,506,491.52 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **137,366,000.00** | **137,366,000.00** | **-** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 82,246,000.00 | 82,246,000.00 | - |
| 210602 | Тавилга | 55,120,000.00 | 55,120,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,381,700.00** | **9,240,100.00** | **3,141,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,280,100.00 | 5,280,100.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,101,600.00 | 3,960,000.00 | 3,141,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **71,651,000.00** | **69,028,569.00** | **2,622,431.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,998,600.00 | 58,382,969.00 | 2,615,631.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,652,400.00 | 10,645,600.00 | 6,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **125,238,000.00** | **84,984,000.00** | **40,254,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **125,238,000.00** | **84,984,000.00** | **40,254,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 125,238,000.00 | 84,984,000.00 | 40,254,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,402,034,400.00** | **1,272,705,500.00** | **129,328,900.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,108,403,700.00** | **1,108,403,700.00** | **-** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,108,403,700.00 | 1,108,403,700.00 | - |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **293,630,700.00** | **164,301,800.00** | **129,328,900.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,280,100.00 | 8,137,800.00 | (2,857,700.00) |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 155,354,000.00 | 156,164,000.00 | (810,000.00) |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 132,996,600.00 | - | 132,996,600.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 132,996,477.00 | (132,996,477.00) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 132,996,477.00 | 196,906,661.84 | (63,910,184.84) |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 261,279.3 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

***Залруулсан алдаа:***

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 10,721.0 мянган төгрөгөөр дутуу тооцож үр дүнгийн тайлан буруу толилуулагдсаныг залруулав.
- Хөрөнгийн дахин үнэлгээ хийж 14,570.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулав.

Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс цаашид давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

**5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт 1*: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 49 ширхэг 421.9 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 11 ширхэг 95.4 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна

*Өгсөн зөвлөмж*: Худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд цахим төлбөрийн нэхэмжлэх үүсгүүлж, төлбөр төлөх үед төлбөрийн баримт үүссэн эсэхийг тогтмол хянаж байх, цахим төлбөрийн баримт олгох газруудаас худалдан авалт хийх.

*Илрүүлэлт 2*: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 48.8 сая төгрөгийн 4 тушаалыг огт мэдээлээгүй байна..

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн зааалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд үнэн, зөв бүрэн байршуулж хэвших.

*Илрүүлэлт 3:* Тайлант жилд 42.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

*Өгсөн зөвлөмж 5:* 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдож Үр дүнгийн тайлан буруу толилуулагдсаныг залруулав. | 1 | 10,721.00 | | | 1 | 10,721.00 | 1 | 10,721.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн боловч санхүүгийн системд журналын бичилт хийгдээгүй байсныг залруулав. | 1 | 14,570.00 | 1 | 14,570.00 | - | - | 1 | 14,570.00 |
| **ДҮН** | **2** | **25,291.00** | **1** | **14,570.00** | **1** | **10,721.00** | **2** | **25,291.00** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 48.8 сая төгрөгийн 4 тушаалыг огт мэдээлээгүй байна. | 1 | 48,814.40 | | | | | 1 | 48,814.40 |
| **ДҮН** | **1** | **48,814.40** | | | | | **1** | **48,814.40** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тайлант жилд 42.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна. | | | | | | | 1 | |
| Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 49 ширхэг 421.9 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 11 ширхэг 95.4 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. | 1 | 95,418.90 | | | | | 1 | 95,418.90 |
| **ДҮН** | **2** | **187,173.90** | | | | | **2** | **187,173.90** |